

# Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих төсөл, АСЕАН-ны туршлагаас суралцах нь (MAPS)



## ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### ➔ Түншлэгч байгууллагууд

Монгол улсын Хөдөлмөрийн яам (ХЯ), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (ХАХНХЯ), Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ), Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ), Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн ажлын алба (АСЕАН-ны ажлын алба), АСЕАН-ны үйлдвэрчний эвлэлийн зөвлөл болон ажил олгогч эздийн холбоо

### Санхүүжүүлэгч байгууллага

➔ Япон улсын Хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам

### Хугацаа

➔ 2014-2015 он

### Зорилтот бүлэг

➔ Монгол улс болон АСЕАН-ны орнуудын шийдвэр гаргах түвшний албан хаагч, мэргэжилтнүүд, Монгол улсын албан бус салбарт ажиллаж байгаа хүмүүс, малчин өрх, хөдөөгийн залуучууд болон өндөр настай иргэд, АСЕАН-ны орнуудын ажилгүй болон бүрэн бус ажил эрхэлж буй хүмүүс

### Хамрах хүрээ

➔ Монгол улс, АСЕАН-ны орнууд



ОУХБ Япон улсын олон/хоёр талт хамтын ажиллагааны хөтөлбөр



## ТӨСЛИЙН ЗОРИЛТ

Монгол улсад хэрэгжүүлж буй энэхүү төсөл нь Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр ОУХБ-ын АСЕАН-ны орнуудад хэрэгжүүлсэн Ажилгүйдлийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих төслийн хоёр дахь үе шат юм.

Эдийн засгийг хүнд чиглүүлж, шударга хуваарилалтын зарчмаар хөгжүүлэхэд нийгмийн хамгааллын тогтолцоо чухал болохыг АСЕАН-ны гишүүн орнууд онцлон тэмдэглэсэн. Үүнтэй холбогдуулан АСЕАН-ны орнууд нийгмийн хамгааллын тогтолцоо, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загварыг шинэчлэн боловсруулж эхлээд байгаа ба ажлын байраа алдсан хүмүүсийг нийгмийн хамгаалалд хамруулах асуудлыг үүнд багтаасан байна. Нийгмийн даатгалд ихэвчлэн албан салбарт ажиллагсад хамрагддаг учраас эмзэг бүлгийнхний хэрэгцээнд нийцэх нийгмийн даатгалын тогтолцоо зайлшгүй шаардлагатай байна.


Монгол улсын эдийн засаг тогтвортой хөгжиж байгаа энэ үед Засгийн газар нийгмийн бодлогыг бэхжүүлэх, нийгмийн хамгааллын доод хэм хэмжээ (НХДХХ)-г тогтоох нь орлогын тэгш хуваарилалтыг дэмжихэд ач холбогдолтой гэж үзэж байна. Монгол улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд заавал төлөх нийгмийн даатгал, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагсдын сайн дурын даатгал, заавал төлөх эрүүл мэндийн даатгал, хүүхдийн мөнгө, нийгмийн халамжийн бусад хөтөлбөрүүд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд багтана. Нийгмийн хамгааллын болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд хүргэж, зохион байгуулах нь хүн амын тархмал суурьшилтай Монгол улсын хувьд бэрхшээлтэй тул малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус салбарт ажиллагсдын 80 хувийн орлогын баталгаа хангагдаж чадахгүй байна.

Энэхүү төсөл нь АСЕАН-ны гишүүн орнууд, Монгол улсын Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудад нийгмийн эмзэг бүлэгт хамаарах ажиллагсад, тэдний гэр бүлийнхэнд зориулсан орлогын баталгаат байдлыг хангах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх стратеги, тогтолцоог боловсруулахад туслалцаа үзүүлнэ. Түүнчлэн малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагсдын өндөр насны тэтгэвэрт хамрагдах хүрээг тэлэх чиглэлээр дэмжлэг үзүүлнэ.

Ази, Номхон далайн бүсийн  
зохистой хөдөлмөрийн  
2006  
2015  
10 жил

ОУХБ-ын Ази болон Номхон далайн бүсийн товчоо

DECENT WORK  
A better world starts here.



## Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг дэмжих төсөл, АСЕАН-ны туршлагаас суралцах нь (MAPS)



### ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсөл нь Монгол улсын Засгийн газар, нийгмийн түншлэлээр дамжуулан АСЕАН-ны ажлын албатай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- АСЕАН-ны орнуудад НХДХХ-г 2015 он гэхэд тогтоох, түүнийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоог эдийн засгийн өсөлттэй уялдуулах,
- АСЕАН-ны орнууд болон Монгол улсын хооронд туршлага солилцох, чадавх бэхжүүлэх болон Өмнөд-өмнөдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, нийгмийн хамгааллын асуудлаар бүсийн семинар зохион байгуулах, шинжээч, зөвлөхүүдийг урьж ажиллуулах, сургалт зохион байгуулах,
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн НХДХХ-г тогтоох асуудлаар бодлогын зөвлөмж боловсруулахад нь Монгол улсын засгийн газар болон нийгмийн түншүүдэд зөвлөмж өгөх,
- Нийгмийн бодлогын уялдааг хангаж орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, НХДХХ-г хэрэгжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлэх,
- Шийдвэр гаргагчид, нийгмийн түншүүд, оролцогч талууд, түүнчлэн олон нийт, залуучуудын дунд нийгмийн хамгааллын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах,
- Эмзэг бүлэгт хамаарах ажилчид, ялангуяа Өвөрхангай, Баянхонгор аймгийн залуу малчдын ур чадварыг хөгжүүлж, орлогын баталгаат байдлыг дээшлүүлэх арга хэмжээ, туршилтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Сургалт, судалгаа, үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах замаар эмзэг бүлгийнхэн, ялангуяа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдын өндөр насны тэтгэврийн хамрах хүрээг нэмэгдүүлэх.

### ТӨСЛИЙН ҮР ДҮН

- АСЕАН болон Монгол улсад нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хоорондын уялдаа холбоо, нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах талаарх ойлголт, сонирхол нэмэгдсэн байна.
- Монгол улсын Засгийн газарт нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үнэлгээнд суурилсан үндэсний хэлэлцүүлгээс боловсруулсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, орлогын баталгаат байдал, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн үндэсний бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түүнд ОУХБ-аас өгсөн зөвлөмжүүд тусгалаа олсон байна.
- Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарын ажилтнуудын өндөр насны тэтгэврийн хамрах хүрээг өргөжүүлэх талаар тодорхой шийдвэр гарсан байна.
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг төв болон орон нутгийн нэг цонхны үйлчилгээний төвүүдээр дамжуулан нэгдмэл байдлаар хүргэх, зохион байгуулалтын механизм, төвлөрлийг сааруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг боловсруулсан байна.

#### ХАЯГ:

С.Байгалмаа, Төслийн үндэсний менежер  
НҮБ-ын байр, Өрөө 105  
Нэгдсэн Үндэстний гудамж -12  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14201, Монгол Улс

Утас: 976 70110640  
Факс: 976 11320625

И-мэйл: [sanjjav@ilo.org](mailto:sanjjav@ilo.org)  
Вэб сайт: [www.ilo.org/asia](http://www.ilo.org/asia)